



**ХБНГУ, Япон, Австрали, БНХАУ зэрэг улсад
иргэний /шүүгчийн/ дүрсийг хууль бусаар
авахад хариуцлага тооцдог эсэх талаарх
лавлагаа**



ЛАВЛАГАА

**Шүүхийн ерөнхий
зөвлөлийн гишүүн
Ж.Эрдэнэчимэгийн
захиалгаар бэлтгэв.**



ГАРЧИГ

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:.....	2
2. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ПРАКТИК	2
2.1. Иргэний /шүүгчийн/ дүрсийг хамгаалах асуудлаар ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт	2
2.2. Япон улсад шүүх хуралдааны зураг, бичлэг хийх асуудал.....	3
2.3. Австрали улсын эрх зүйн зохицуулалт, практик.....	5
2.4. БНХАУ-ын эрх зүйн зохицуулалт, практик.....	6
3. ДҮГНЭЛТ	8
ХАВСРАЛТ	9
Иргэний /шүүгчийн/ дүрсийг олон нийтэд үзүүлэхтэй холбоотой гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт	9
Дүрс зургийн эрхтэй холбоотой БНХАУ-ын кейс	11





ХБНГУ, ЯПОН, АВСТРАЛИ, БНХАУ ЗЭРЭГ УЛСАД ШҮҮГЧИЙН ДҮРСИЙГ ХУУЛЬ БУСААР АВАХАД ХАРИУЦЛАГА ТООЦОХ ТАЛААРХ ЛАВЛАГАА¹

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 2 дугаар зүйлийн 2.27 дах хэсэгт “Хүн бүр эдийн болон сэтгэл зүйн хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй” гэсэн бол Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ... эрхтэй” гэж заасан байдаг. Харин шүүгчийн дүрсийг хууль бусаар авч олон нийтэд үзүүлснээс эдийн бус гэм хор учирсан тохиолдолд хэрхэн нэхэмжлэх, хохирлын хэмжээг хэрхэн үнэлэх, мөнгөн хэлбэрээр эдийн бус гэм хорыг нэхэмжилж болдог эсэх асуудлыг судлах зорилготойгоор ХБНГУ, Япон, Австрали, БНХАУ-ын эрх зохицуулалт болон практикийн талаарх мэдээллийг харьцуулан бэлтгэлээ. Харьцуулсан судалгаа хийх улсуудыг сонгохдоо эрх зүйн бүл болон эрх зүйн хөгжлийг харгалзав.

Түлхүүр үг: шүүгчийг дүрсийг хууль бусаар буулгаж авах, олон нийтэд сурталчлах, түгээх, хариуцлага тооцох

2. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ПРАКТИК

2.1. Иргэний /шүүгчийн/ дүрсийг хамгаалах асуудлаар ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт

ХБНГУ-д хувь хүний дүрсийг хамгаалах үзэл санаа эртний уламжлалтай бөгөөд “Урлагийн бүтээл, гэрэл зургийн зохиогчийн эрхийн тухай” (Kunsturhebergesetz, KUG) 1907 оны хуулийн 22 дахь хэсэгт хувь хүний дүрсийг хамгаалах эрхийн тухай албан ёсоор хүлээн зөвшөөрч тусгасан. Өөрөөр хэлбэл, 22 дахь хэсэгт зааснаар тухайн гэрэл зургийг нийтлэхийн өмнө дүрслүүлэгчээс зөвшөөрөл авах ёстой талаар тусгасан.

Үүнээс өмнө энэ асуудал 1889 онд хоёр гэрэл зурагчин Германы канцлер асан Otto von Bismarck-ын унтлагын өрөөнд нэвтрэн түүний цогцсын гэрэл зургийг зөвшөөрөлгүй авснаас эхэлсэн байдаг. Энэ чиглэлээр хамгийн алдартай Marlene Dietrich-гийн хэрэгт хувь хүний дүрсийг хамгаалах нь тухайн этгээдийн материаллаг бус ашиг сонирхлыг хамгаалахад чиглэх, түүнчлэн тухайн ашиг сонирхол санхүүгийн үнэ цэнэтэй байх буюу хохирлыг мөнгөөр үнэлж болох талаар тусгасан байдаг. Эндээс дүгнэхэд, Германы эрх зүйд хувь хүний дүрсийг хамгаалах асуудал нь тухайн гомдлын онцлогоос хамаарч гэм

¹ Тус лавлагааг Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Мандах, шүүхийн судалгаа хариуцсан ахлах референт Э.Өлзийлхам (МА, LL.M), судлаачид Б.Ариунзаяа, Л.Галбаатар нар гүйцэтгэсэн болно.



хор, зохиогчийн эрх, хүний зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх зэргээр холимог шинжтэй байдаг.²

Орчин үед ХБНГУ-ын хариуцагчаар татагдсан нэгэн хэрэгт нийтийн албан тушаалтны дүрсийг хамгаалах асуудлаар Хүний эрхийн Европын шүүхээс шийдвэрлэсэн байна.³ Тодруулбал, “Von Hannover V. Germany (No. 2)” хэргийн нэхэмжлэгч нь гүнж Caroline von Hannover бөгөөд тэрээр Германы шүүхэд түүний хувийн амьдралтай холбоотой гэрэл зургийн хоёр цувралыг түүний зөвшөөрөлгүйгээр сэтгүүлд нийтэлсэн явдлыг зогсоолгохоор нэхэмжлэл гаргасан. Нэхэмжлэлийн үндэслэлдээ түүний хувийн амьдралын халдашгүй байдал болон дүрсээ хамгаалуулах эрх зөрчигдсэн гэжээ. Энэ хэрэг Германы гурван шатны шүүхээр орсон бөгөөд Холбооны Үндсэн хуулийн шүүх 1999 онд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.⁴

Ингээд нэхэмжлэгч нь түүний гэрэл зургуудыг зөвшөөрөлгүй нийтэлсэн нь “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай” Европын конвенцийн 8-р зүйлд баталгаажуулсан хувийн амьдралаа хүндэтгэлтэй хандуулах эрхийг зөрчсөн гэж үзэж Хүний эрхийн Европын шүүхэд хандсан. Европын хүний эрхийн шүүхийн шүүгчид санал нэгтгэйгээр Европын конвенцийн 8-р зүйлд баталгаажуулсан эрх зөрчигдөөгүй байна гэж 2012.02.07-ны өдөр шийдвэрлэсэн. Ийм шийдвэр гаргах болсон үндэслэлээ дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

- Үндэсний шүүх нь шийдвэр гаргахдаа хувь хүний амьдралын халдашгүй байдлыг хангах болон гэрэл зургууд нийтэлсэн компанийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх буюу хэвлэн нийтлэх эрхийн тэнцвэрийг хангасан байна. Ингэхдээ ямар гэрэл зургийг авч нийтэлсэн талаар дүгнэлт хийжээ.
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд гэрэл зураг нийтлэх хамаарах бөгөөд тухайн гэрэл зургууд нь хувь хүний нэр төрийг гутаасан шинжгүй байна.

Эндээс дүгнэхэд иргэний дүрсийг аливаа хэлбэрээр нийтэлснээс гэм хор учирсан эсэхийг тогтоох нөхцөл нь хэвлэн нийтлэх эрхийг зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэхээс хамаарахаар байна.

2.2. Япон улсад шүүх хуралдааны зураг, бичлэг хийх асуудал

Япон улсад шүүх хуралдааны явцын тухай зураг авах, бичлэг хийх нь зарчмын хувьд хориотой. Гагцхүү Ерөнхий шүүгч зөвшөөрсөн тохиолдолд зураг авч, бичлэг хийж болно. Энэ тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай журмын 215 дугаар зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай журмын 77 дугаар зүйлд заажээ. Зураг авах, бичлэг хийх камер нь жижиг оврын

² Image Right and Copyright Law in Europe: Divergences and Convergences by Tatiana Synodinou, Law Department, University of Cyprus. 2014. p. 185. ISSN 2075-471X www.mdpi.com/journal/laws/

³ Factsheet – Right to the protection of one’s image. Press Unit, European Court of Human Rights http://www.echr.coe.int/Documents/FS_Own_image_ENG.pdf

⁴ Von Hannover V. Germany (No. 2). 40660/08 60641/08 | Judgment (Merits and Just Satisfaction) | Court (Grand Chamber) | 07/02/2012 <http://hudoc.echr.coe.int/eng/?i=001-109029#{'itemid': '001-109029'}>



1 ширхэг мэргэжлийн камертай бичлэг хийнэ. Үүнээс өөр тоног төхөөрөмжүүд болох гэрэлтүүлэгч, дуу хураагуур, шууд дамжуулах хэрэгсэл зэргийг шүүх хуралдааны танхимд авч орохыг хориглоно.

Эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд зураг, бичлэгийг гагцхүү хохирогч байхгүй үед хийж болно. Гагцхүү шүүгч, шүүгчдийн суудал, оролцогчдын суудал зэргийг дүрс бичлэгт буулгаж авахыг зөвшөөрнө.

Шүүх хуралдааны бичлэг хийхэд дараах зүйлсийг хориглоно. Үүнд:

- шүүгчээс өөр шүүх хуралдааны оролцогчдын дүрс бичлэг, зургийг авахыг хориглоно;
- үзэгчдийн суудлаас үзэж сонирхож буй бусад этгээдүүдийн дүрс бичлэг, зургийг авахыг хориглоно;
- шүүх хуралдааны оролцогчдын дүрс бичлэг, зургийг авахыг хориглоно.

Зураг авах, бичлэг хийх зөвшөөрөл авсан этгээд нь шүүгчийг энэ ажиллагааг дуусгахыг шаардсаны даруйд бичлэг, зураг авалтаа шууд дуусгаж, шүүх хуралдааны танхимыг орхиж гарна.⁵ Зураг авч бичлэг хийх хугацаа нь 2 минут байх бөгөөд энэ хугацаанд гагцхүү шүүгч танхимд орж ирэх, шүүх хуралдаан эхэлснийг зарлах хүртэлх хугацааг багтаана. 2 минут дуусмагц бичлэг, зураг авалтыг нэн даруй зогсоох үүрэг хүлээнэ.

Зөвшөөрөлгүй зураг, бичлэг хийсэн тохиолдолд хүлээх хариуцлага

Зөвшөөрөлгүйгээр шүүгч болон оролцогчдын зургийг авсан тохиолдолд тодорхой хариуцлага оногдуулдаггүй. Гагцхүү тухайн зураг, бичлэгийг нийтэлсэн сонин, хэвлэлээс зураг, бичлэгийг устгахыг шаарддаг байна.⁶ Шүүгчийн зургийг авах үйлдэл нь хувь этгээдийн зургийг авсан гэсэн үндэслэлээр хүний өөрийн зургийн эрх чөлөөнд⁷ халдсан гэж үздэг байна. Хувь хүний зургийн эрх нь хувийн эрхтэй нэгэн адилаар Япон улсын Үндсэн хуулиас бий болсон эрх юм.

Энэ эрх нь зөрчигдсөн этгээд Иргэний хуулийн гэм хорын эрх зүйгээр нөхөн төлбөр шаардах эрхтэй. Гэхдээ зураг авах зорилго нь орчныг харуулах байсан бөгөөд санамсаргүй байдлаар хувь этгээдийн нүүр царай орчихсон, эсхүл ингэж орсон ч ашиглахдаа тухайн этгээдийн нүүрийг бүдгэрүүлсэн байвал хариуцлага хүлээхгүй. Мөн нүүр царай тод гарсан ч тухайн этгээдэд ялимгүй хохирол учруулсан бол хувийн эрхэд халдсан гэж үзэхгүй юм.⁸

Одоогоор Япон улсад шүүгчийн өөрийн дүрсний эрх зөрчигдсөн гэсэн асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдол байхгүй байна. Шүүгчийн

⁵ http://www.pressnet.or.jp/statement/report/910101_88.html

⁶ Шүүх хуралдааны явцыг хуулиар хориглох нь үндэслэлгүй <http://d.hatena.ne.jp/gyou/20131023/p1>

⁷ Өөрийн гадаад байдлыг нийтэд ил гаргахгүй байх эрх 肖像権 (Portrait right)

⁸ Мизүхо хуулийн фирмийн цахим хуудас <http://www.mc-law.jp/kiqyohomu/4984/>



хувьд тусгай албан тушаалтан тул хүлцэн тэвчих үүрэг гэж байх ба шүүгчийн зургийг авах нь хүлцэн тэвчих хязгаарыг давсан тохиолдолд хувийн эрхэд нь халдсан гэж үздэг байна. Үүнийг тогтоохдоо тухайн зургийг авах үеийн орчин нөхцөл байдал, зураг авсан зорилго, шаардлага зэргийг харгалзан үзнэ.⁹

2.3. Австрали улсын эрх зүйн зохицуулалт, практик

Австрали улс жишгийн эрх зүйн улс орны тоонд ордог бөгөөд шүүх дээр зураг авах явдал хязгаарлагдмал байдаг. Англи-саксоны эрх зүйн бүлд хамааралтай улс орнууд ихэвчлэн шүүхэд зураг авах, бичлэг хийхийг хориглодог. Сэтгүүлчид шүүхийн байр, орчин тойрны дүрс, дуут бичлэгийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр авахыг хориглодог бөгөөд эдгээрийг хэвлэн нийтлүүлэх, зурагтаар дамжуулахад зөвшөөрөл авдаг. Гэхдээ шүүхийн зураг зурдаг мэргэшсэн зураачдаар зураг зуруулахыг зөвшөөрдөг.¹⁰ Австралийн Дээд шүүхэд зочилсон аливаа иргэн шүүхэд ороод харуулд нь камер, радио, пейжер, дуу тоглуулагч, дуу хураагч, гар утас болон бусад электрон эд зүйлийг хураалгах шаардлагатай байдаг. Шүүхийн захиргааны ажилтнаас бусад хүн шүүх хуралдааны аудио бичлэг хийхийг хориглодог. Шүүх хуралдаан болсноос хойш 1-2 хоногийн дараа хурлын тэмдэглэлтэй танилцаж болдог.¹¹

“Contempt of court” буюу шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, зүй бусаар нөлөөлөхийг оролдох нь шүүхийг ноцтойгоор үл хүндэтгэсэн явдал болдог. Сэтгүүлчдийн хувьд дан ганц бичиж, хэлсэн үгнээс гадна зураг авах, дуу буулгах зэрэг нь шүүхийг үл хүндэтгэсэн гэж үзэхэд хүргэж болно. Энэхүү жишгийн эрх зүйн зарчмаар иргэд, олон нийтийн шүүгчийн хараат бус байдалд итгэх итгэлийг бууруулахаас урьдчилан сэргийлэх зорилготой байдаг. Шүүгчийг шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлснийх нь төлөө айлган сүрдүүлэх, зүй бусаар халдах нь шүүхийг үл хүндэтгэсэнд тооцогдоно.

Жишээ нь, хэрэг хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчээс шүүгчид доромжилсон өнгө аястай захиа бичих, тухайн хэргийг шүүгчээр шийдвэрлүүлэхгүй тулд олон нийтийн газар шүүгчийг доромжилсон өнгө аястай үг хэлэх, хэрэг нь өөрийнх хүссэнээр шийдэгдээгүй шүүгдэгч доромжилсон өнгө аястай захидлыг шүүгчид илгээх зэрэг нь энэ зөрчилд тооцогдоно.¹² Үүний нэгэн адил сэтгүүлчид болон бусад хүмүүс шүүгчийг зургийг хууль бусаар авч, олон нийтэд үзүүлсэн явдал нь шүүгчийг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцогдох бөгөөд энэ зөрчлийнх нь төлөө шүүгч зөрчил гаргасан этгээдийг баривчлах эсхүл торгох шийтгэл оногдуулдаг. Зарим тохиолдолд тухайн этгээдийг шүүгчийн хүссэн хугацаагаар хорьж болдог. Үүнд, тухайн этгээд гэм буруугаа хүлээн

⁹ Мизүхо хуулийн фирмийн цахим хуудас <http://www.mc-law.jp/kigyohomu/4984/>

¹⁰ The News Manual: A professional resources for journalists and the media http://www.thenewsmanual.net/Resources/medialaw_in_australia_03.html

¹¹ High Court of Australia: <http://www.hcourt.gov.au/about/court-etiquette>

¹² LexisNexis, Halsbury's Laws of Australia (1 January 2008) 105 Contempt, '2 Criminal Contempt' [105–130].



зөвшөөрч, чин сэтгэлээсээ уучлал хүсч, цаашид шүүхийн шийдвэрийг хэлбэрэлтгүй дагах үүргийг авч, суллагдах боломжтой.

Хэрэв шүүгчийг аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай нь холбогдолгүйгээр нэр хүндийг нь гутаан доромжлох зорилгоор түүнийг зургийг авч, олон нийтэд түгээсэн бол 2006 оны Австралийн нэр хүнд гутаан доромжлохын эсрэг нэгдсэн хуулийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргаж болдог. Тус хуульд тухайн хүний талаар буруу ташаа мэдээллийг хэлсэн үг, бичлэг, эсхүл харагдах дүрс зэргийг ашиглан хэвлэн нийтэлснээр тухайн хүн болон түүний гэр бүлийн гишүүдийн нэр хүндийг гутаан доромжилсон, эсхүл түүнийг эрхэлж буй ажилд гэм хор учруулсан, эсхүл түүнийг бусад хүмүүс үзэн ядаж, жигшин зэвүүцэхэд хүргэх аливаа үйлдлийг нэр хүндийг гутаан доромжлох гэж үздэг байна.¹³ Австрали улсад эдийн бус гэм хорын ойлголт өргөн хүрээтэй зохицуулагддаг бөгөөд түүнийг үнэлэх, арилгах журмыг буюу эдийн бус гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээг хуульчилсан байдаг. Тухайлбал, эд хөрөнгийн хохирлыг шүүхээс 0-60 түвшинд хуваан авч үзэж хохирлыг үнэлэхээр заажээ. Австралийн нэр хүнд гутаан доромжлохын эсрэг нэгдсэн хуульд эдийн бус гэм хор учруулсан тохиолдолд түүнийг үнэлэх мөнгөн дүнгийн дээд хэмжээг 250,000 австрали доллар байхаар зохицуулсан байна.

2.4. БНХАУ-ын эрх зүйн зохицуулалт, практик

БНХАУ-д дүрсний эрхийг хөрөг зургийн эрх гэдэг бөгөөд энэ нь иргэн өөрийн хувийн дүрс зургийг зөвхөн өөрийн мэдлээр ашиглах бөгөөд бусдын зургийг зөвшөөрөлгүй ашиглавал хувь хүний дүрсний эрхэд халдсан үйлдэл болохыг илэрхийлсэн ойлголт юм.¹⁴

БНХАУ-ын Иргэний хуулийн ерөнхий зарчмын 100-р зүйлд заасны дагуу иргэн өөрийн хөрөг зургийн эрхтэй байх ба түүний зөвшөөрөлгүй ашиг олох зорилгоор ашиглахыг хориглоно. Үүнээс үзэхэд иргэний хөрөг зургийн эрхэд халдсан гэж үзэхэд дараах 2 нөхцөл бүрэлдсэн байх ёстой.¹⁵

1. Тухайн иргэний зөвшөөрлийг аваагүй
2. Ашиг олох зорилгоор

Тухайн иргэний зөвшөөрөлгүйгээр бусдын зургийг бизнесийн сурталчилгаа, барааны тэмдэг (баглаа боодол), ном сэтгүүлийн нүүр, календарь гэх мэт ашиг олох зорилгоор удаа дараа ашиглаж иргэний хөрөг зургийн эрхийг зөрчсөн тохиолдолд хохирогч өөрийн мэдлээр зогсоох, бүх гаргасан материалыг хураах, нээлттэй гаргасан үзүүлэн материалыг устгах зэрэг арга хэмжээ авах эрхтэй. Мөн хуулийн дагуу саад учруулахыг зогсоох,

¹³ The News Manual: A professional resources for journalists and the media
http://www.thenewsmanual.net/Resources/medialaw_in_australia_02.html

¹⁴ 李昌麒.民法商法经济法实用辞典.北京: 中国经济出版社, 2002, (Ли Чанги, Иргэний эрх зүй, худалдаа, эдийн засгийн эрх зүйн практик толь бичиг. Бээжин, 2002 он)

¹⁵ <http://baike.baidu.com/view/105845.htm>



хохирлоо барагдуулахыг шаардах эрхтэй. Хохирлоо барагдуулах хүсэлт гаргах эрх нь хөрөнгийн хохирол барагдуулах нөхцөлтэй байж болохгүй.

Бусад хуулийн акт болон хуулийн тайлбарт иргэний хөрөг зургийн эрхэд халдахтай холбоотой тайлбарыг БНХАУ-ын Ардын Дээд шүүх гаргасан байна. Тухайлбал, “БНХАУ-ын Иргэний хуулийн ерөнхий зарчмын зарим асуудлыг нэг мөр хэрэгжүүлэх зөвлөмж”-ийн 139-р заалтад ашиг олох зорилгоор иргэний хөрөг зургийг өөрийн зөвшөөрөлгүй зар сурталчилгаанд ашиглах, барааны тэмдэг, үзмэр зэрэгт ашиглахыг хөрөг зургийн эрхэд халдсан гэж үзнэ гэж заасан. Түүнчлэн садар самуун, гутаан доромжилсон, иргэний хөрөг зургийг ашиглан гүтгэсэн тохиолдолд иргэний хөрөг зургийн эрхэд халдсан гэж үзнэ.

Хохирлыг нөхөн төлөх

Иргэний хөрөг зургийн эрх зөрчигдсөн тохиолдолд ихэвчлэн сэтгэл санааны нөхөн төлбөр байна. БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн “Иргэний эрхэд халдсаны улмаас үүссэн сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хариуцлагыг тогтоох тухай тайлбар”-ын 10 дугаар заалт: Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг дараах байдлаар тогтооно.¹⁶

1. Зөрчил гаргагчийн зөрчлийн хэмжээ, хуульд өөрөөр заагаагүй бол,
2. Эрхэд халдсан үе, байр байдал, үйлдлийн арга барил болон тодорхой үйл явдал;
3. Эрхэд халдсан үйлдлээс гарсан хор уршиг;
4. Зөрчил гаргагчийн олсон ашгийн хэмжээ;
5. Зөрчил гаргагчийн хариуцлага хүлээх эдийн засгийн чадамж, байдал;
6. Зарга хүлээн авсан газрын шүүхийн тухайн газрын амьдралын түвшин.

Хариуцлага хүлээх тухай

БНХАУ-ын “Иргэний хуулийн ерөнхий зарчим”-ын 120-р зүйлд заасны дагуу хувь хүний овог нэр, дүрс зураг, нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдсан тохиолдолд иргэн зөрчлийг зогсоох, нэр төрөө сэргээлгэх, нөлөөлсөн хор уршгийг арилгуулах, уучлалт гуйлгах, нөхөн төлбөр гаргуулах эрхтэй.

2009 онд батлагдсан “БНХАУ-ын гэм хорын хариуцлагын тухай хууль”-д энэ тухай нарийвчлан заасан байдаг. Тус хуулийн 2 дугаар зүйлд иргэний эрх ашигт халдсан тохиолдолд тус хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Иргэний эрх ашигт хөрөг зургийн эрх ордог байна. Тус хуулийн 6 дугаар зүйлд: “Иргэний эрх ашигт халдсан гэм хор учруулсан этгээд нь заавал хариуцлага хүлээнэ”. Мөн тус хуульд 2-оос дээш этгээд хамтран иргэний эрх ашигт халдсан бол хамтран хариуцлага хүлээнэ гэж заасан ба гэм хор учруулахад өдөөн хатгах, туслах үйлдэл гаргасан бол хамтран хариуцлага хүлээнэ гэж заасан.¹⁷

¹⁶ 杨立新《人格权法》，北京：中国法制出版社，2006，第 227 页。（Янг Лишин, Хүний эрхэм чанар, Бээжин, 2006 он, 227 дахь тал.)

¹⁷ http://www.gov.cn/flfg/2009-12/26/content_1497435.htm



Тус хуулийн 15 дугаар зүйлд иргэний эрх ашгийг зөрчсөн бол дараах хариуцлага хүлээлгэдэг байна. Үүнд:

1. Зөрчлийг зогсоох;
2. Саад бэрхшээлийг арилгах;
3. Аюулыг арилгах;
4. Хөрөнгийг буцаах;
5. Хэвийн байдалд нь оруулах;
6. Нөхөн төлбөр төлөх;
7. Уучлал гуйх;
8. Гарсан үр дагаврыг арилгах, нэр төрийг сэргээх.

3. ДҮГНЭЛТ

Дээр судалсан эрх зүйн өндөр хөгжилтэй улс орнууд болох ХБНГУ, Япон болон Австрали зэрэг улсад шүүх хуралдааны зураг болон бичлэг авах асуудлыг хуулиар нарийн зохицуулсан байна. Тухайлбал, Япон улсад шүүх хуралдааныг ямар төрлийн камераар бичлэг хийх, шүүн таслах ажиллагааны тодорхой хэсгүүдийг авах талаарх нарийн дэг журам тогтоожээ. Тус улсад шүүгч нь бусад хүний нэгэн адил өөрийн дүр зургийг эзэмших эрхтэй бөгөөд үүнийгээ зөрчигдсөн гэж үзвэл мөнгөн дүнгээр эдийн бус хохирлыг нэхэмжилж болдог байна.

Германы эрх зүйд хувь хүний дүрсийг хамгаалах асуудал нь тухайн гомдлын онцлогоос хамаарч гэм хор, зохиогчийн эрх, хүний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зэргээр холимог шинжтэй байдаг байна.

Харин шүүгчийн зургийг түүний зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар авсан тохиолдолд Австрали улсад жишгийн эрх зүйн “шүүхийг үл хүндэтгэсэн” хэмээх зөрчилд тооцож, зөрчил гаргасан этгээдийг баривчлах болон торгууль оногдуулах зэрэг хатуу арга хэмжээ авдаг байна. Австрали улсад эдийн бус гэм хорын ойлголт өргөн хүрээтэй зохицуулагддаг бөгөөд түүнийг үнэлэх, арилгах журмыг буюу эдийн бус гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээг хуульчилсан бөгөөд шүүгч нэр хүндээ гутаан доромжилсон гэж үзвэл шүүхэд мөн нэхэмжлэл гаргаж, мөнгөн дүнгээр сэтгэл санааны хохирлоо тооцуулж болохоор байна.

БНХАУ-ын хувьд дүрс зургийн эрх нь иргэний эрхийн нэг хэсэг бөгөөд Иргэний хуулиар болон Гэм хорын хариуцлагын тухай хуулийн дагуу энэхүү эрх нь зөрчигдөж, гэм хор учирсан гэж үзвэл зөрчлийг зогсоох, нөхөн төлбөр төлөхийг шаардах, уучлал гуйхыг шаардах, гарсан үр дагаврыг арилгах, нэр төрийг сэргээхийг нэхэмжилж шүүхэд хандаж болдог байна.

Эцэст нь дүгнэхэд, аливаа этгээд иргэний дүрсийг аливаа хэлбэрээр ашигласнаас гэм хор учирсан гэж үзвэл эдгээр улсад эдийн болон эдийн бус хэлбэрээр гэм хор арилгуулахаар нэхэмжлэх эрхтэй байна.



ХАВСРАЛТ

Иргэний /шүүгчийн/ дүрсийг олон нийтэд үзүүлэхтэй холбоотой гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт¹⁸

<i>Иргэний дүрс, зургийг олон нийтэд үзүүлэхэд зөвшөөрөл шаардлагатай эсэхтэй холбоотой улс орнуудын мэдээлэл¹⁹</i>			
Улсын нэр	Зураг авах	Зургийг нийтлэх	Нийтлэгдсэн зургийг арилжааны зорилгоор ашиглах
Австрали	Үгүй (зарим тохиолдолд)	Үгүй (зарим тохиолдолд)	Тийм
Австри	Үгүй	Үгүй (зарим тохиолдолд)	Тийм
Аргентин	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
Афганистан	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
Макао	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
Мексик	Үгүй	Тийм	Тийм
АНУ	Үгүй	Үгүй	Ихэвчлэн (гэхдээ муж улс бүр өөр хуультай)
Бельги	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм
БНХАУ	Үгүй	Үгүй	Тийм
Бразил	Тийм	Тийм	Тийм
Грек	Үгүй	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)
Дани	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
ИБУИНВУ	Нөхцөл байдлаас хамаарна	Нөхцөл байдлаас хамаарна	Нөхцөл байдлаас хамаарна
Израиль	Үгүй	Үгүй (зарим тохиолдолд)	Тийм
Испани	Үгүй	Тийм	Тийм
Итали	Үгүй	Үгүй	Тийм
Канад	Үйл ажиллагаанаас хамаарна	Тийм (зарим тохиолдолд)	Тийм
Ливи	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм
Нидерланд	Үгүй	Үгүй (зарим тохиолдолд)	Үгүй (зарим тохиолдолд)
Норвеги	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)

¹⁸ Судлаач Л.Галбаатар орчуулан бэлтгэв. 2016.01

¹⁹ Commons: Country specific consent requirements

https://commons.wikimedia.org/wiki/Commons:Country_specific_consent_requirements



ОХУ	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
ӨАБНУ	Үгүй	Үгүй	Тийм
Перу	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
Польш	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм
Португали	Үгүй (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)	Тийм
Сингапур	Үгүй (зарим тохиолдолд)	Үгүй (зарим тохиолдолд)	Үгүй (зарим тохиолдолд)
Словек	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
Словени	Үгүй	Үгүй	Тийм
Тайван	Үгүй	Үгүй (зарим тохиолдолд)	Тийм
Унгар	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
Финланд	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
Франц	Тийм (зарим тохиолдолд)	Тийм	Тийм
ХБНГУ	Үгүй (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
ХонгКонг	Нөхцөл байдлаас хамаарна	Нөхцөл байдлаас хамаарна	Нөхцөл байдлаас хамаарна
Чех	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
Швед	Үгүй	Үгүй	Тийм
Швейцар	Үгүй	Тийм	Тийм
Шинэ Зеланд	Үгүй (зарим тохиолдолд)	Үгүй (зарим тохиолдолд)	?
Энэтхэг	Үгүй	Үгүй (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)
Этиоп	Үгүй	Тийм (зарим тохиолдолд)	Тийм
Япон	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)	Тийм (зарим тохиолдолд)



Дүрс зургийн эрхтэй холбоотой БНХАУ-ын кейс²⁰

2011 оны 9 сарын 24-ний орой БНХАУ-ын Хайнан хотын үл хөдлөх хөрөнгийн “Жэнг Да” ХХК (цаашид “Жэнг Да” гэх) зохион байгуулсан “мөрөөдлийн амьдрах орчин” сэдэвт үйл ажиллагаанд Хонг Конгийн жүжигчин Рэн Дахуа (Simon Yam) хүндэт зочноор оролцсон. Үйл ажиллагаа дууссаны дараа Жэнг да ХХК нь түүний зөвшөөрөлгүйгээр жүжигчин Рэн Дахуагийн зургийг бизнесийн сурталчилгаа болгон үл хөдлөх хөрөнгийн газрын гадна талд байршуулсан байна. Рэн Дахуа 2011 оны 9 сарын 24-ний өдрийн тус үйл ажиллагаанд оролцоход түүний нэр болон зургийг бусад мэдээллийн хэрэгслээр бизнесийн зар сурталчилгаанд ашиглахгүй байхаар Жэнг да ХХК тай тохирсон хэдий ч, Жэнг да ХХК зар сурталчилгааг 2011.9-2012.3 сар хүртэл нийт 100 өдөр ашигласныг нэхэмжлэгч тал болох Рэн Дахуа түүний дүрсний эрхэд халдсан гэж үзжээ. Түүнчлэн 2012.3.26-ны өдөр тус байгууллагаас олон нийтийн хэрэгслээр уучлал гуйж, нэр төрөө сэргээлгэх мөн эдийн засгийн хохирол болох 1 000 000 юань болон сэтгэл санааны хохирол болох 100 000 юаныг нэхэмжилжээ. Гэвч Жэнг Да ХХК нь заалдагч талтай гэрээ хийхдээ түүнд үйл ажиллагаанд оролцсоны хөлс, унааны зардал, үйл ажиллагаанд оролцох зөвшөөрлийн хөлс зэрэг тохирох хэмжээний хөлсийг төлсөн бөгөөд зургийг 2 удаа ашиглахаар тохирч 2011.9.19-9.24; 2012.1.21-2.9-нийг хүртэл ашигласан учир эрхэд халдаагүй гэж үзжээ.

БНХАУ-ын Хай Коу хотын анхан шатны шүүх зөрчил гаргагчийн алдаа, эрхэд халдсан үйлдлийн хор уршиг, нөхцөл байдлыг үндэслэн Жэнг Да ХХК-д 200 000 юаны хохирлыг барагдуулах, БНХАУ-ын Хай Коу хотын олон нийтийн хэрэгслээр уучлал гуйхыг даалгаж шийдвэрлэсэн байна.

Гэвч заалдагч тал 2013.3 сард БНХАУ ын Хай Коу хотын бүс нь хүн ам ихтэй, нийгэмд хүчтэй нөлөөтэй бүс нутаг бөгөөд, түүний эрх урт хугацаагаар, хүндээр зөрчигдсэн, зургийг ашигласан нийт хугацаа нь 100 өдөр гэдгийг батлах, түүнтэй холбоотой бусад нотлох баримтуудыг гаргаж нөхөн төлбөр 1 000 000 юань, сэтгэл санааны 100 000 юаныг дахин нэхэмжилсэн. Жэнг Да ХХК нь нотолгоо бүрэн бус, сэтгэл санааны хохирлын хэмжээг хуульд нийцүүлэн шийдээгүй, мөн нэхэмжлэгч талын дүрс зургийг удаан ашиглаагүй зэрэг шалтгаанаар нөхөн төлбөрийг багасгаж 70 000 юань болгох хүсэлтийг нэхэмжлэгч талд удаа дараа тавьсан боловч 2 тал тохиролцоонд хүрэлгүй давж заалдах гомдол гаргасан.

Давж заалдах шатны бүсийн дээд шүүх Жэнг Да ХХК-ын заалдагч талд учруулсан бодит хохирлыг “БНХАУ-ын гэм хорын хариуцлагын тухай хууль”-ийн дагуу тогтоож анхан шатны шүүхийн шийдвэрээр Жэнг Да ХХК нь заалдагч тал Рэн Дахуад 200 000 юань нөхөн олгохоор шийдвэрлэсэн байна.

²⁰ http://www.hq.xinhuanet.com/legal/2013-11/18/c_118179416.htm